



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Засаг даргын тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2020/117/СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.dornogovi.audit.mn

Сайншанд хот
2020 он

Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа

Утас: 70522734 Цахим хаяг: Dornogovi@audit.gov.mn

Аудитын менежер: Э.Энхцэцэг

Утас: 70523020 Цахим хаяг: enkhtsetseg.e@audit.gov.mn

Аудитор: О.Нарангарав

Утас: 70523020 Цахим хаяг: Narangarav.o@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |

Агуулга

| | |
|---|----|
| Аудитын гэрчилгээ | 3 |
| 2. Аудитын тайлан..... | 5 |
| 2.1. Оршил | 5 |
| 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага | 5 |
| 2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт | 5 |
| 2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин | 6 |
| 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ | 6 |
| 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал | 6 |
| 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар | 6 |
| 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд | 7 |
| 2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга..... | 8 |
| 2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн..... | 9 |
| 2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал | 10 |
| 2.12. Шилэн дансны мэдээлэл | 10 |
| 2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт | 10 |
| 2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл..... | 10 |
| 3. Менежментийн захидал | 11 |
| 4. Аудит хийгдсэн санхүүгийн тайлан | 12 |
| 4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан..... | 12 |
| 4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан | 13 |
| 4.2 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан | 15 |
| 4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан | 17 |
| 4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан..... | 18 |
| 4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан..... | 20 |

Аудитын гэрчилгээ



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34

2020.02.27 № 1-6/124

танай _____ -ны № _____ -т

ДОРНОГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Б.ГАНЗОРИГ ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Засаг даргын тамгын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Дорноговь аймгийн Засаг даргын тамгын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дорноговь аймгийн Засаг даргын тамгын газар нь 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

010020020

Үүрэг, хариуцлага

Дорноговь аймгийн Засаг даргын тамгын газар нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Дорноговь аймгийн Засаг даргын тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг байгууллагын дарга Б.Ганзориг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй, болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Засаг даргын тамгын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Засаг даргын тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 14-ээс 2020 оны 02 дугаар сарын 18-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 27-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор О.Нарангарав хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Засаг даргын тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 3/222 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Дорноговь аймгийн Засаг даргын тамгын газрын үйл ажиллагааны эрхэм зорилго нь "Стратегийн төлөвлөгөө, бодлогын удирдамжийн хэрэгжилт, хөтөлбөр, төслийн биелэлт зэргийг Засаг даргын дэргэдэх газар, хэлтэс, алба, албан байгууллага, аж ахуйн нэгжид хэрхэн хэрэгжиж байгааг хянах, шалгах, зохицуулах, чиглэл өгөх, мэдээлэл авах, хүний нөөцийнх нь манлайлалд үнэлгээ өгөх зэрэг эрхтэйгээс гадна дээрх байгууллагаар дамжуулан мэдээллийг цуглуулж хяналт шинжилгээ хийх дүгнэлт гаргах үүрэгтэй ажиллана"-д оршино.

Дорноговь аймгийн Засаг даргын тамгын газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн санал хүсэлтийг шийдвэрлэж төрийн үйлчилгээг хүргэх

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Дорноговь аймгийн Засаг даргын тамгын газар нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд "Acolous" программ хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Засаг даргын тамгын газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Дорноговь аймгийн Засаг даргын тамгын газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 2 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны 2019 оны хүлээгдэж буй гүйцэтгэлийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг "дунд" гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 2,163,812.4 мянган төгрөгөөс тооцон 21,628.1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 26,063.2 мянган төгрөгөөр тооцсон нь материаллаг байдлыг 2019 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр тооцсон тул

өөрчлөн 2019 оны жилийн эцсийн тайлангаар материаллаг байдлыг тодорхойлох нь зүйтэй гэж үзэн нийт зардлын 1%-аар тодорхойлов.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Дорноговь аймгийн Засаг даргын тамгын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 314,370.6 мянган төгрөгөөр буюу 20.4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага 69,385.8 мянган төгрөг, бараа материал 8,699.7 мянган төгрөг, цэвэр үндсэн хөрөнгө 236,285.1 мянган төгрөг, өр төлбөр 934.7 мянган төгрөг, цэвэр хөрөнгө өмчийн дүн 313,435.9 мянган төгрөгөөр тус тус өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | /мянган төгрөг/ Зөрүү | |
|------------|---|---------------------|---------------------|--------------------------|--------------|
| | | | | Дүн | Хувь |
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 135,550.77 | 213,636.30 | 78,085.53 | 57.61 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | - | - | - | - |
| 32 | БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ | - | - | - | - |
| 33 | АВЛАГА | 45,400.56 | 114,786.41 | 69,385.85 | 152.83 |
| 34 | УРЬДЧИЛГАА | - | - | - | - |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 90,150.21 | 98,849.89 | 8,699.69 | 9.65 |
| 36 | НӨӨЦИЙН БАРАА | - | - | - | - |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 1,405,582.93 | 1,641,868.03 | 236,285.11 | 16.81 |
| 37 | УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ | - | - | - | - |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 1,405,582.93 | 1,641,868.03 | 236,285.11 | 16.81 |
| | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | 1,541,133.69 | 1,855,504.33 | 314,370.64 | 20.40 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 11,966.55 | 12,901.25 | 934.70 | 7.81 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 11,966.55 | 12,901.25 | 934.70 | 7.81 |
| 42 | УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | - | - | - | - |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 1,529,167.14 | 1,842,603.08 | 313,435.94 | 20.50 |
| | НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 1,541,133.69 | 1,855,504.33 | 314,370.64 | 20.40 |

Авлага дансны үлдэгдэл 69,385.8 мянган төгрөгөөр өссөн нь өмнөх оны нэмэлт дансны татан төвлөрүүлэлтийн авлага 45,400.6 мянган төгрөг бүрэн барагдаж, тайлант онд нэмэлт дансны татан төвлөрүүлэлт 114,786.4 мянган төгрөгийг авлагаар бүртгэсэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 8,699.7 мянган төгрөгөөр өссөн нь бичиг хэрэг 289.8 мянган төгрөг, аж ахуйн материал 20,998.9 мянган төгрөг, түлш шатах тослох материал 481.9 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж, бусад хангамжийн материал 13,071.0 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 410,012.0 мянган төгрөгөөр өссөн нь барилга байгууламж 122,820.0 мянган төгрөг, авто тээврийн хэрэгсэл 89,500.0 мянган төгрөг, машин тоног төхөөрөмж 101,939.5 мянган төгрөг, тавилга эд хогшил 58,752.1 мянган төгрөг, бусад үндсэн хөрөнгө 9,000.0 мянган төгрөг, программ хангамж 28,000.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэнтэй холбоотой байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 151,421.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, орон нутгийн хөрөнгө оруулалтаар 335,170.5 мянган төгрөгийн барилга байгууламж, авто тээврийн хэрэгсэл, машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил зэрэг үндсэн хөрөнгө олгогдсоныг данс бүртгэлд тусгасан байна.

Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2019 оны 74 дүгээр тогтоолоор 75,140.0 мянган төгрөгийн авто тээврийн хэрэгслийг НҮГазарт, 1,440.8 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг Прокурорын газар, АШУҮИС-ийн Дорноговь салбарт тус тус балансаас балансад шилжүүлэн данс бүртгэлээс хассан байна.

Биет бус хөрөнгө 28,000.0 мянган төгрөгөөр өссөн нь ХШҮ-ний цахим сангийн программ худалдан авсантай холбоотой байна.

Тайлант онд үндсэн хөрөнгөнд нийт 174,224.8 мянган төгрөгийн элэгдлийн зардал нэмэгдэж, данснаас хассан хөрөнгийн 498.3 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдлийг бүртгэлээс хасаж, цэвэр үндсэн хөрөнгө нийт дүнгээрээ 236,285.1 мянган төгрөгөөр өссөн байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 934.7 мянган төгрөгөөр өссөн нь өмнө оны Засгийн газрын нөөц сангийн илүү санхүүжилтийн өр төлбөр 11,966.5 мянган төгрөгийг бүрэн барагдуулж, тайлант онд цэргийн дүйцүүлэх орлогын 50 хувийн дутуу төвлөрүүлэлт 12,901.2 мянган төгрөгийн өр төлбөрийг нэмж бүртгэсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,842,603.1 мянган төгрөг болж 313,435.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн нэмэгдсэн нь шалтгаалжээ. Энэ нь тайлант онд хөрөнгө оруулалтаар үнэ төлбөргүй үндсэн хөрөнгө нэмэгдсэнийг илэрхийлж байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

| Дансны код | Орлогын ангилал | Тайлант оны | | Тайлант оны зөрүү | |
|------------|--------------------------------|-----------------------|---------------------|-------------------|---------------|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Дүн | Хувь |
| 1310 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 2,287,076.10 | 2,287,076.10 | - | 100.00 |
| | Нийт дүн | 2,287,076.10 | 2,287,076.10 | - | 100.00 |

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 2,287,076.1 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 2,287,076.1 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 2,287,076.1 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Орон нутгийн төсвөөс 2,287,076.1 мянган төгрөгийн санхүүжилттэй ажилласан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,258,106.2 мянган төгрөг буюу 98.7 хувьтай байна. Албан хаагчдын цалин, НДШ-ийн зардал 1,083,960.5 мянган төгрөг нь нийт зардлын 48.0 хувь, бараа ажил үйлчилгээний бусад зардал 1,169,151.1 мянган төгрөг нь

нийт зардлын 51.8 хувь, урсгал шилжүүлгийн зардал 4,994.5 мянган төгрөг нь нийт зардлын 0.2 хувийг тус тус эзэлж байна.

Жилийн эцэст өмнөх оны буцаж орсон орлого 10.0 мянган төгрөг, урсгал зардлын хэмнэлт 28,969.9 мянган төгрөг, нийт 28,979.9 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсөв: Үндэсний архивын газраас 2 гэрээт ажилтны цалин 16,881.1 мянган төгрөг, Засгийн газрын хэрэг эрхлэх газраас шилдэг аймгийн урамшуулал 20,000.0 мянган төгрөг, БХЯ-аас сургалт дайчилгааны санхүүжилт 5,546.5 мянган төгрөг, эргүүлэн төлөх нөхцөлтэй олгосон санхүүжилтийн буцаан төлөлт 8,270.0 мянган төгрөг, нэмэлт дансаар дамжин хэрэгжсэн арга хэмжээний санхүүжилт 4,178.5 мянга төгрөг, захиалагчийн техник хяналтын орлого 209,212.4 мянган төгрөг, цэргийн дүйцүүлэх болон торгуулийн орлого 84,252.3 мянган төгрөг, архивын тасгийн үйл ажиллагааны орлого 7,599.5 мянган төгрөг, өвсний орлого 12,248.5 мянган төгрөг, дэлгэц түрээсийн орлого 60.0 мянган төгрөг, урьд оны төвлөрүүлэлтийн буцаан олголт 45,400.5 мянган төгрөг, төсвийн урамшуулал 2,931.9 мянган төгрөг, нийт 416,581.3 мянган төгрөгийн эх үүсвэрийг холбогдох дансанд бүртгэсэн байна.

Нийт санхүүжилтийн зарцуулалтыг авч үзвэл гэрээт ажилтны цалин, НДШ-ийн зардалд 21,697.1 мянган төгрөг, цэргийн дүйцүүлэх орлогын 50 хувийн төвлөрүүлэлт 27,000.0 мянган төгрөг, Аймгийн засаг даргын захирамжаар цэргийн штабын үйл ажиллагаанд 57,287.0 мянган төгрөг, ХШҮ-ний цахим сайтын зардал 28,000.0 мянган төгрөг, үндсэн хөрөнгө худалдан авахад 19,534.1 мянган төгрөг, өмнө онд татан төвлөрүүлэлтээс үүсэн өр төлбөрт 11,966.5 мянган төгрөг, бусад үйл ажиллагаанд 136,310.2 мянган төгрөг нийт 301,794.9 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 114,786.4 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 2 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 2 эрсдэл тодорхойлж нийт 4 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 292,646.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 271,454.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 12,901.2 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 8,291.7 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 12,901.2 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил илэрснээс 12,901.2 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Орлогын данстай холбоотой асуудал

Цэргийн дүйцүүлэх албаны мөнгөн төлбөрийн орлого нэмэлт дансанд нийт 79,802.5 мянган төгрөг төвлөрснөөс Сангийн яамны төрийн сангийн дансанд 39,901.2 мянган төгрөгийг төвлөрүүлэхээс 12,901.2 мянган төгрөгийг дутуу төвлөрүүлсэн байна.

Энэ нь Үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Засгийн газрын 2016 оны 215 дугаар тогтоолоор батлагдсан “Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэний тоо, бүртгэл хөтлөх, мөнгөн төлбөрийг төлөх, хураан авах, төлбөрийн орлогыг ашиглах журам”-ын 3.2-т “... цэргийн дүйцүүлэх албыг орлуулан хаасан мөнгөн төлбөрийн 50 хувийг Сангийн яамны Төрийн сангийн тусгай дансанд төвлөрүүлнэ” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Аудитаар албан шаардлага тогтоохоор шийдвэрлэв

Аудитаар илэрсэн 8,291.7 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

- Нэмэлт дансанд захиалагчийн техник хяналтын зардлын 209,212.4 мянган төгрөгийн орлого төвлөрсөн байх боловч захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэхэд хэдэн төгрөгийн зарцуулалт гарсан нь тодорхой бус байна.

- Тайланд оны тээвэр шатахууны батлагдсан төсөв 41,583.2 мянган төгрөг, мөн багаж хэрэгсэл, тавилга эд хогшлын зардлаас 41,992.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авахдаа худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна.

Дараагийн аудитаар дээрх асуудлуудыг нарийвчлан авч үзэх шаардлагатай.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Дорноговь аймгийн Засаг даргын тамгын газар нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 149 мэдээллийг хугацаанд нь байршуулж, 2 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 60.3 сая төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгснөөс зөвлөмжийг хэрэгжүүлж, хэрэгжилт 100 хувьтай байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорноговь аймгийн Засаг даргын тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Дорноговь аймгийн Засаг даргын тамгын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 дахь заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Бага үнэтэй түргэн элэгдэх, ахуйн эд зүйлийн болон урсгал засварын зардлуудыг зориулалт бусаар зарцуулж 8,291.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан байна.

Энэ нь Үнэн зөв байдал батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 16.5.5 дахь заалт, Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалыг тус тус зөрчсөн байна.

1.2 Эрсдэл: Төсвийн гүйцэтгэлийн тайлан буруу тайлагнагдах, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах эрсдэлтэй.

1.3 Өгсөн зөвлөмж: Цаашид Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалд заасны дагуу батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, тайлагнах.

1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Өгч буй зөвлөмжид санал байхгүй гэсэн хариу тайлбарыг баталгаажуулан ирүүлсэн байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2020 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|------------|---|--------------------------------|--------------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | <u>135,550,766.80</u> | <u>213,636,300.50</u> |
| 33 | АВЛАГА | 45,400,558.30 | 114,786,407.00 |
| 335 | Бусад авлага | 45,400,558.30 | 114,786,407.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 45,400,558.30 | 114,786,407.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 90,150,208.50 | 98,849,893.50 |
| 354 | Хангамжийн материал | 90,150,208.50 | 98,849,893.50 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,167,272.00 | 1,457,152.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 53,982,936.50 | 74,981,848.50 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | - | 481,893.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 35,000,000.00 | 21,929,000.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | <u>1,405,582,927.61</u> | <u>1,641,868,033.52</u> |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 1,405,582,927.61 | 1,641,868,033.52 |
| 392 | Биет хөрөнгө | 1,308,171,427.51 | 1,523,656,533.52 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 936,748,000.00 | 1,059,568,000.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | - | (44,202,917.28) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 422,467,800.00 | 511,967,800.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (215,242,134.86) | (260,738,633.38) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 248,465,713.00 | 350,405,253.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (178,475,076.77) | (224,326,081.47) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 225,859,819.00 | 284,611,929.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (132,208,744.02) | (161,649,517.07) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 2,141,604.00 | 11,141,604.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (1,585,552.84) | (3,120,903.28) |
| 393 | Биет бус хөрөнгө | 97,411,500.10 | 118,211,500.00 |
| 39301 | Програм хангамж | 16,100,000.00 | 44,100,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (6,412,499.88) | (13,412,499.94) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 88,324,000.00 | 88,324,000.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | (600,000.02) | (800,000.06) |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | <u>1,541,133,694.41</u> | <u>1,855,504,334.02</u> |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | <u>11,966,550.00</u> | <u>12,901,252.00</u> |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 11,966,550.00 | 12,901,252.00 |
| 413 | Өглөг | 11,966,550.00 | 12,901,252.00 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 11,966,550.00 | 12,901,252.00 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | <u>1,529,167,144.41</u> | <u>1,842,603,082.02</u> |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 1,529,167,144.41 | 1,842,603,082.02 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 1,335,190,111.52 | 1,335,190,111.52 |
| 51101 | Өмч: - төрийн | 1,335,190,111.52 | 1,335,190,111.52 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 42,660,480.65 | 356,096,418.26 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 42,660,480.65 | 42,660,480.65 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 313,435,937.61 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 151,316,552.24 | 151,316,552.24 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | <u>1,541,133,694.41</u> | <u>1,855,504,334.02</u> |

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|---|-------------------------|-------------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 2,630,493,817.02 | 2,981,600,390.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 240,173,800.00 | 335,630,500.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 240,173,800.00 | 335,630,500.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 240,173,800.00 | 335,630,500.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 10,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 240,173,800.00 | 335,620,500.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 2,390,320,017.02 | 2,645,969,890.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 397,946,717.02 | 358,893,790.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 146,033,450.00 | 20,000,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 17,049,951.00 | 2,931,927.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 216,776,716.00 | 335,961,863.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 1,992,373,300.00 | 2,287,076,100.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 1,992,373,300.00 | 2,287,076,100.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 2,429,325,461.33 | 2,606,315,952.39 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 2,429,325,461.33 | 2,606,315,952.39 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 2,340,525,999.33 | 2,572,341,511.39 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 793,309,166.00 | 987,566,284.00 |
| 210101 | Үндсэн цалин | 517,097,566.00 | 616,282,685.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 51,798,000.00 | 57,099,000.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 224,413,600.00 | 314,184,599.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 88,917,928.00 | 118,091,313.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 58,434,096.00 | 80,571,680.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,528,505.00 | 9,154,048.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,609,227.00 | 7,241,357.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,470,583.00 | 1,803,351.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 15,875,517.00 | 19,320,877.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 167,514,078.00 | 217,139,865.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 10,051,629.00 | 11,562,712.00 |
| 210302 | Түлш, халаалт | 152,760,353.00 | 202,435,425.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4,702,096.00 | 3,141,728.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 89,141,445.00 | 97,625,098.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 15,319,153.00 | 14,153,812.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 53,175,233.00 | 62,351,368.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 20,407,059.00 | 20,132,932.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 240,000.00 | 986,986.00 |
| 2105 | Нормативт зардал | 1,584,000.00 | 6,505,400.00 |

| | | | |
|-------------|--|------------------------------|------------------------------|
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,584,000.00 | 6,505,400.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 34,263,169.00 | 37,834,130.00 |
| 210604 | Урсгал засвар | 34,263,169.00 | 37,834,130.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 36,645,890.00 | 93,817,852.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 23,097,150.00 | 23,773,700.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | 13,548,740.00 | 70,044,152.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 934,222,727.00 | 772,584,293.30 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 930,606,297.00 | 768,821,105.30 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 576,000.00 | 403,200.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 2,454,900.00 | 2,795,780.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 495,352.00 | 464,208.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 90,178.00 | 100,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 194,927,596.33 | 241,177,276.09 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 139,656,614.00 | 65,885,652.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,000,000.00 | 1,066,800.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 54,270,982.33 | 174,224,824.09 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 88,799,462.00 | 33,974,441.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | - | 4,994,500.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 4,994,500.00 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | - | 28,979,941.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 28,979,941.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | <u>201,168,355.69</u> | <u>375,284,437.61</u> |
| 145 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН | 30,558,500.00 | 14,234,000.00 |
| 145002 | Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз | 30,558,500.00 | 14,234,000.00 |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 91,537,504.27 | 76,082,500.00 |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 222,000.14 | 76,082,500.00 |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | (60,979,004.27) | (61,848,500.00) |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | <u>140,189,351.42</u> | <u>313,435,937.61</u> |

4.2 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|---|--------------------------------|--------------------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | <u>2,468,159,696.30</u> | <u>2,709,814,975.30</u> |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 8,267,754.00 | 360,000.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 8,267,754.00 | 360,000.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 8,267,754.00 | 360,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 8,267,754.00 | 360,000.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 2,459,891,942.30 | 2,709,454,975.30 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 460,392,246.30 | 416,581,348.30 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 158,000,000.00 | 20,000,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 17,049,951.00 | 48,332,485.30 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 247,572,150.00 | 348,248,863.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 1,992,373,300.00 | 2,287,076,100.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 1,992,373,300.00 | 2,287,076,100.00 |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | 7,126,396.00 | 5,797,527.00 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 7,126,396.00 | 5,797,527.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | <u>2,439,815,496.30</u> | <u>2,558,393,045.30</u> |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 2,439,815,496.30 | 2,558,393,045.30 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 2,305,615,476.00 | 2,382,632,197.30 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 791,520,242.00 | 987,566,284.00 |
| 210101 | Үндсэн цалин | 515,308,642.00 | 616,282,685.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 51,798,000.00 | 57,099,000.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 224,413,600.00 | 314,184,599.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 90,706,852.00 | 118,091,313.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 60,223,320.00 | 80,571,680.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,528,505.00 | 9,154,048.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,609,227.00 | 7,241,357.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,470,583.00 | 1,803,351.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 15,875,217.00 | 19,320,877.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 167,514,078.00 | 217,071,565.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 10,051,629.00 | 11,494,412.00 |
| 210302 | Түлш, халаалт | 152,760,353.00 | 202,435,425.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4,702,096.00 | 3,141,728.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 89,697,993.00 | 100,707,947.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 16,268,161.00 | 13,999,768.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 52,602,773.00 | 62,993,261.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 20,407,059.00 | 20,132,932.00 |

| | | | |
|-------------|---|------------------------------|-------------------------------|
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 240,000.00 | 986,986.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 180,000.00 | 2,595,000.00 |
| 2105 | Нормативт зардал | 1,584,000.00 | 6,505,400.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,584,000.00 | 6,505,400.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 25,611,345.00 | 52,503,184.00 |
| 210602 | Тавилга | 00.00 | 435,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 25,611,345.00 | 52,067,684.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 35,203,296.00 | 86,621,909.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 23,097,150.00 | 23,773,700.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | 12,106,146.00 | 62,848,209.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 943,182,484.00 | 784,329,718.30 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 939,561,027.00 | 780,566,530.30 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 581,027.00 | 403,200.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 2,454,900.00 | 2,795,780.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 495,352.00 | 464,208.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 90,178.00 | 100,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 160,595,186.00 | 29,234,877.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 159,595,186.00 | 27,917,477.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,000,000.00 | 1,317,400.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 134,200,020.30 | 175,760,848.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 00.00 | 4,994,500.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 00.00 | 4,994,500.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 134,200,020.30 | 141,786,407.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 134,200,020.30 | 27,000,000.00 |
| 213405 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 114,786,407.00 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 00.00 | 28,979,941.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 28,979,941.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | <u>28,344,200.00</u> | <u>151,421,930.00</u> |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 28,344,200.00 | 151,421,930.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 28,344,200.00 | 151,421,930.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 28,344,200.00 | 151,421,930.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 28,344,200.00 | 151,421,930.00 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | <u>-28,344,200.00</u> | <u>-151,421,930.00</u> |

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|--|---------------------------------|-----------------------|------------------------|---|
| 2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 1,248,166,111.52 | 181,328,920.83 | -155,641,458.27 | 1,273,853,574.08 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 1,248,166,111.52 | 181,328,920.83 | -155,641,458.27 | 1,273,853,574.08 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 320,334,773.57 | 320,334,773.57 |
| 2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 1,335,190,111.52 | 151,316,552.24 | 42,660,480.65 | 1,529,167,144.41 |
| 2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 1,335,190,111.52 | 151,316,552.24 | 42,660,480.65 | 1,529,167,144.41 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 1,335,190,111.52 | 151,316,552.24 | 42,660,480.65 | 1,529,167,144.41 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 313,435,937.61 | 313,435,937.61 |
| 2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 1,335,190,111.52 | 151,316,552.24 | 356,096,418.26 | 1,842,603,082.02 |

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Үзүүлэлт | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|-------------------------|-------------------------|----------------------|---------------|
| НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 2,287,076,100.00 | 2,258,106,159.00 | 28,969,941.00 | 98.73 |
| УРСГАЛ ЗАРДАЛ | 2,287,076,100.00 | 2,258,106,159.00 | 28,969,941.00 | 98.73 |
| БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 2,282,076,100.00 | 2,253,111,659.00 | 28,964,441.00 | 98.73 |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 970,018,600.00 | 968,279,985.00 | 1,738,615.00 | 99.82 |
| Үндсэн цалин | 613,776,300.00 | 616,282,685.00 | (2,506,385.00) | 100.41 |
| Унаа хоолны хөнгөлөлт | 61,344,000.00 | 57,099,000.00 | 4,245,000.00 | 93.08 |
| Гэрээт ажлын хөлс | 294,898,300.00 | 294,898,300.00 | - | 100.00 |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 116,045,400.00 | 115,680,529.00 | 364,871.00 | 99.69 |
| Тэтгэврийн даатгал | 82,116,000.00 | 78,928,959.00 | 3,187,041.00 | 96.12 |
| Тэтгэмжийн даатгал | 8,482,400.00 | 8,961,185.00 | (478,785.00) | 105.64 |
| ҮОМШӨ-ний даатгал | 6,609,100.00 | 7,087,069.00 | (477,969.00) | 107.23 |
| Ажилгүйдлийн даатгал | 1,873,300.00 | 1,764,777.00 | 108,523.00 | 94.21 |
| Эрүүл мэндийн даатгал | 16,964,600.00 | 18,938,539.00 | (1,973,939.00) | 111.64 |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 225,541,400.00 | 217,071,565.00 | 8,469,835.00 | 96.24 |
| Гэрэл, цахилгаан | 11,885,200.00 | 11,494,412.00 | 390,788.00 | 96.71 |
| Түлш, халаалт | 208,242,200.00 | 202,435,425.00 | 5,806,775.00 | 97.21 |
| Цэвэр, бохир ус | 5,414,000.00 | 3,141,728.00 | 2,272,272.00 | 58.03 |
| Хангамж, бараа материалын зардал | 83,351,000.00 | 83,276,142.00 | 74,858.00 | 99.91 |
| Бичиг хэрэг | 13,014,800.00 | 12,298,568.00 | 716,232.00 | 94.50 |
| Тээвэр, шатахуун | 41,583,200.00 | 40,416,256.00 | 1,166,944.00 | 97.19 |
| Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 19,393,000.00 | 19,588,432.00 | (195,432.00) | 101.01 |
| Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,000,000.00 | 986,986.00 | 13,014.00 | 98.70 |
| Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 8,360,000.00 | 9,985,900.00 | (1,625,900.00) | 119.45 |
| Нормативт зардал | 6,505,400.00 | 6,505,400.00 | - | 100.00 |
| Нормын хувцас, зөөлөн эдлэл | 6,505,400.00 | 6,505,400.00 | - | 100.00 |
| Эд хогшил, урсгал засварын зардал | 139,962,700.00 | 139,674,084.00 | 288,616.00 | 99.79 |
| Багаж, техник, хэрэгсэл | 78,240,700.00 | 78,132,100.00 | 108,600.00 | 99.86 |
| Тавилга | 19,300,000.00 | 15,700,700.00 | 3,599,300.00 | 81.35 |
| Урсгал засвар | 42,422,000.00 | 45,841,284.00 | (3,419,284.00) | 108.06 |
| Томилолт, зочны зардал | 94,691,600.00 | 86,621,909.00 | 8,069,691.00 | 91.48 |

Дорноговь аймгийн Засаг даргын Тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

| | | | | |
|--|-------------------------|-------------------------|---------------------|----------------|
| Дотоод албан томилолт | 34,691,600.00 | 23,773,700.00 | 10,917,900.00 | 68.53 |
| Зочин төлөөлөгч хүлээн авах | 60,000,000.00 | 62,848,209.00 | (2,848,209.00) | 104.75 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 634,400,000.00 | 624,881,245.00 | 9,518,755.00 | 98.50 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 630,000,000.00 | 621,118,057.00 | 8,881,943.00 | 98.59 |
| Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 600,000.00 | 403,200.00 | 196,800.00 | 67.20 |
| Даатгалын үйлчилгээ | 2,800,000.00 | 2,795,780.00 | 4,220.00 | 99.85 |
| Тээврийн хэрэгслийн татвар | 600,000.00 | 464,208.00 | 135,792.00 | 77.37 |
| Тээврийн хэрэгслийн оношлогоо | 100,000.00 | 100,000.00 | - | 100.00 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 11,560,000.00 | 11,120,800.00 | 439,200.00 | 96.20 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 10,000,000.00 | 9,803,400.00 | 196,600.00 | 98.03 |
| Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,560,000.00 | 1,317,400.00 | 242,600.00 | 84.45 |
| УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 5,000,000.00 | 4,994,500.00 | 5,500.00 | 99.89 |
| Бусад урсгал шилжүүлэг | 5,000,000.00 | 4,994,500.00 | 5,500.00 | 99.89 |
| Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 5,000,000.00 | 4,994,500.00 | 5,500.00 | 99.89 |
| ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 2,287,076,100.00 | 2,287,086,100.00 | (10,000.00) | 100.00 |
| ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 2,287,076,100.00 | 2,287,076,100.00 | - | 100.00 |
| Орон нутгийн төсвөөс | 2,287,076,100.00 | 2,287,076,100.00 | - | 100.00 |
| Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | | | - | #DIV/0! |
| ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | - | 10,000.00 | (10,000.00) | #DIV/0! |
| Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 10,000.00 | (10,000.00) | #DIV/0! |

4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|-------------|---|------------|-----------------------|
| I | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 0.0 | 274,794,941.30 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 0.0 | 274,794,941.30 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 0.0 | 274,794,941.30 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 0.0 | 19,286,299.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 0.0 | 19,286,299.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 0.0 | 2,410,784.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 0.0 | 1,642,721.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 0.0 | 192,863.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 0.0 | 154,288.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 0.0 | 38,574.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 0.0 | 382,338.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 0.0 | 24,822,705.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 0.0 | 1,701,200.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 0.0 | 22,577,005.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 0.0 | 544,500.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 0.0 | 12,561,208.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 0.0 | 5,434,008.00 |
| 210604 | Урсгал засвар | 0.0 | 7,127,200.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 0.0 | 203,747,395.30 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 0.0 | 203,747,395.30 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 0.0 | 11,966,550.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 0.0 | 11,966,550.00 |
| II | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 0.0 | 389,581,348.30 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 0.0 | 389,581,348.30 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 0.0 | 20,000,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 0.0 | 48,332,485.30 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 0.0 | 321,248,863.00 |